



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

АВТО ЗАМЫН АШИГЛАЛТЫН БАЙДАЛД
ХЯНАЛТ ТАВИХ, ТӨЛБӨР АВАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЛААР АВАХ ЗАРИМ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай" Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах цэгийн байршлыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад даалгасугай:

2.1. Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан төлбөр авах цэгийн байршлыг Монгол Улсын авто замын сүлжээний зурагт тэмдэглэж олон нийтэд мэдээлэхийг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ (Б.Мандат)-т, хяналт тавьж ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Доржханд)-т тус тус;

2.2. Монгол Улсын авто замын сүлжээн дэх олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах үйл ажиллагааг зохион байгуулахыг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ (Б.Мандат)-т;

2.3. Төлбөр авах цэгүүдийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, шинээр барихад шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тогтоож, улсын авто замын сан болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгө, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжүүлэн барьж байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газар (Ю.Өлзийжаргал)-т, Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Доржханд)-т тус тус;

2.4. Төлбөр авах цэгийг төлөвлөх, барьж байгуулах, түүнд тавигдах шаардлагыг тогтоох талаар зохих стандарт, норм, дүрэм, журам боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газар (Ю.Өлзийжаргал)-т, Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Доржханд)-т тус тус;

2.5.Энэхүү тушаалын хавсралтаар батлагдсан цэгүүдэд олон улсын болон улсын чанартай авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр авах, авто замын ашиглалтын байдал, замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих хяналтуудыг нэг цэгт төвлөрүүлэн хэрэгжүүлэхийг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Доржханд)-т, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (П.Билгүүн)-т, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ (Б.Мандат)-т, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ (Н.Пунцаг)-т тус тус;

2.6.Авто зам, замын байгууламжаар зайлшгүй тохиолдолд даац хэтэрсэн, зөвшөөрөгдсөнөөс илүү овор, хэмжээтэй тээврийн хэрэгслээр зорчих тохиолдолд зөвшөөрөл олгох зохицуулалтыг шинэчлэх талаар зохих дүрэм, журам, стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэхийг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Доржханд)-т.

3.Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (П.Билгүүн)-т даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Зам, тээврийн хяналт зохицуулалт, олон улсын болон улсын чанартай авто зам дээгүүр зорчиж буй тээврийн хэрэгслээс төлбөр авах талаар авах зарим арга хэмжээний тухай” Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 127 дугаар тушаал, “Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх төлбөртэй авто зам /замын чиглэл, урт/, замын байгууламжийн жагсаалт батлах тухай” Зам, тээврийн сайдын 2014 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 190 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  М.ЗОРИГТ

2016 оны 04 сарын 24 өдрийн 100 дугаар
Зам, тээврийн сайдын
тушаалын хавсралт

УХА0115 5919487

ОЛОН УЛС БОЛОН УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭН ДЭХ ТӨЛБӨРТЭЙ АВТО ЗАМ,
ТӨЛБӨР АВАХ ЦЭГИЙН БАЙРШИЛ

№	Авто замын дугаар	Авто замын чиглэлийн нэр	Төлбөр хураах цэгийн нэр	Төлбөр хураах цэгийн байршил	Төлбөртэй авто замын эхлэл, төгсгөлийн цэг		Замын урт /км/
					Эхлэлийн цэг	Төгсгөлийн цэг	
Үйл ажиллагаа явуулж байгаа төлбөр авах цэг							
1	A0101	Налайх-Чойр	Хоолтын төлбөр авах цэг	Улаанбаатар хотоос 40км-т Хоолтын давааны наана	Налайх Чойрын салдаг уулзвар	Чойр хот	198
2	A0103	Сайншанд-Замын-Үүд-Улсын хил	Замын-Үүдийн төлбөр авах цэг	Замын-Үүд сумын орчимд	Сайншанд хот	Замын-Үүд сум	218
				Замын-Үүд сумын Хилийн цэргийн байцаан өнгөрүүлэх цэг дээр	Замын-Үүд сум	Улсын хил	
3	A0201 A25	Улаанбаатар-Мандалговь Өндөрдов-Зуунмод-Налайх	Өлзийтийн төлбөр авах цэг	Өлзийт хороолол Зуунмод хотын авто замын уулзварын орчимд	Зуунмод хот Өлзийт тосгон салдаг уулзвараас	Мандалговь хот	260
						Налайх	29
4	A0301	Улаанбаатар-Арвайхээр	Цанын баазын төлбөр авах цэг	Цанын бааз орчимд	Улаанбаатар хотоос 19 км-т	Арвайхээр хот	412
5	A0301	Улаанбаатар-Арвайхээр	Онгийн гүүрийн төлбөр авах цэг	Онгийн гүүрийн орчимд	Арвайхээр хот	Улаанбаатар хотоос 19 км-т	412
6	A0302	Арвайхээр-Баянхонгор	Түйн гол төлбөр авах цэг	Түйн гүүрийн орчимд	Баянхонгор хот	Арвайхээр хот	200
7	A0401	Улаанбаатар-Дархан	Рашаантын төлбөр авах цэг	Рашаантын гармын орчимд	Улаанбаатар хотоос 19 км-т	Дархан	206
8	A0402	Улаанбаатар-Дархан	Дарханы төлбөр авах цэг	Дархан Эрдэнэтийн салдаг уулзварын орчимд	Дархан хот	Улаанбаатар хотоос 19 км-т	168

№	Авто замын дугаар	Авто замын чиглэлийн нэр	Төлбөр хураах цэгийн нэр	Төлбөр хураах цэгийн байршил	Төлбөртэй авто замын эхлэл, төгсгөлийн цэг		Замын урт /км/
					Эхлэлийн цэг	Төгсгөлийн цэг	
9	A0402 A0403	Дархан-Сүхбаатар	Дулаанхааны төлбөр авах цэг	Дулаанхаан дөрвөн замын уулзварын орчимд	Дархан	Сүхбаатар хот, Алтанбулаг сум	113
10	A0501 A24	Улаанбаатар-Өндөрхаан Налайх-Тэрэлж	Налайх-Тэрэлжийн төлбөр авах цэг	Тэрэлж Багануурын авто замын уулзварын орчимд	Налайх-Тэрэлжийн салдаг уулзвараас	Баруун Хэрлэнгийн төмөр бетон гүүр, Тэрэлжийн амралт	116
11	A0501	Улаанбаатар-Өндөрхаан	Хэрлэнгийн гүүрийн төлбөр авах цэг	Баруун Хэрлэнгийн төмөрбетон гүүрийн орчимд	Хэрлэнгийн төмөр бетон гүүр	Өндөрхаан хот	196
12	A0601 A0602	Элсэнтасархай-Хархорин	Хужиртын төлбөр авах цэг	Хархорин хужирт чиглэлийн авто замын 2-р тасгийн орчимд	Элсэнтасархайн уулзвараас	Хархорин сум- Цэцэрлэг	188
13	A0603	Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг	Ганцмодны төлбөр авах цэг	Цагаан давааны ар Хар туулайтын аманд	Цэцэрлэг хот	Тосонцэнгэл сум	350
14	A0902	Булган-Мөрөн	Гуртын гүүрийн төлбөр авах цэг	Гуртын гүүрийн орчимд	Булган хот	Мөрөн хот	342
15	A1001	Дархан-Эрдэнэт	Хангалын нүүрийн төлбөр	Хангалын гүүрийн орчимд	Дархан хот	Эрдэнэт хот	168
16	A1702	Улаангом-Хандгайт улсын хил	Хангайтын төлбөр авах цэг	Улаангом хотын төвөөс гарах 5км-т	Улаангом хот	Хандгайт улсын хил	113
Шинээр баригдсан, баригдаж байгаа төлбөр авах цэг							
17	A0102	Чойр-Сайншанд-Замын-Үүд	Айрагийн төлбөр авах цэг	Айраг сумын орчимд	Айраг сум	Замын-Үүд сум	342
18	A0201	Улаанбаатар-Мандалговь	Мандалговийн төлбөр авах цэг	Мандалговь хотын орчимд	Түргэний гүүр	Мандалговь хот	246
19	A12	Манхан-Булган-Улсын хил	Булганы төлбөр авах цэг	Булган сумын орчимд	Ховд чиглэлийн замын уулзвар, Манхан сум	Булган, Улсын хил	354
20	A2001	Өндөрхаан-Баруун хот	Баруун-Уртын төлбөр авах цэг	Баруун урт хотын орчимд	Чойбалсан чиглэлийн замын уулзвар	Баруун урт хот	178
Шинээр баригдах төлбөр авах цэг							
21	A0202	Мандалговь -Даланзадгад	Даланзадгадын төлбөр авах цэг	Цогтцэций сумын салааны орчимд	Мандалговь хот	Даланзадгад хот	302

№	Авто замын дугаар	Авто замын чиглэлийн нэр	Төлбөр хураах цэгийн нэр	Төлбөр хураах цэгийн байршил	Төлбөртэй авто замын эхлэл, төгсгөлийн цэг		Замын урт /км/
					Эхлэлийн цэг	Төгсгөлийн цэг	
22	A0303	Баянхонгор-Алтай	Алтайн төлбөр авах цэг	Алтай хотын орчимд	Баянхонгор хот	Алтай хот	398
23	A0304	Алтай- Ховд	Ховдын төлбөр авах цэг	Ховд хотын орчимд	Алтай хот	Ховд хот	451
24	A0305	Ховд-Өлгий	Өлгийн төлбөр авах цэг	Өлгий хотын орчимд	Ховд хот	Өлгий хот	222
25	A0501	Улаанбаатар-Өндөрхаан	Өндөрхааны төлбөр авах цэг	Өндөрхаан хотын орчимд	Багануур, Хэрлэнгийн гүүр	Өндөрхаан хот	196
26	A0502	Өндөрхаан-Чойбалсан	Чойбалсангийн төлбөр авах цэг	Чойбалсан хотын орчимд	Өндөрхаан хот	Чойбалсан хот	308
27	A0902	Булган-Мөрөн	Мөрөнгийн төлбөр авах цэг	Мөрөн хот орчимд	Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр	Мөрөн хот	198
28	A0603	Цэцэрлэг-Тосонцэнгэл-Нөмрөг	Тосонцэнгэлийн төлбөр авах цэг	Тосонцэнгэл сумын орчимд	Тосонцэнгэл сум	Цэцэрлэг хот	350
29	A18	Нөмрөг-Сонгино-Улаангом	Улаангомын төлбөр авах цэг	Улаангом хотын орчим	Тосонцэнгэл сум	Улаангом хот	514
30	A27	Лүн-Дашинчилэн-Өгийнуур	Баяннуурын төлбөр авах цэг	Баяннуур сумын орчим	Лүнгийн уулзвар	Орхоны гүүр	172

___ оОо ___